



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/111

Мөрөн сум

Цэрэг татлагын товчоо байгуулах,  
урьдчилсан үзлэг явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 13.6, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 94 дүгээр зүйлийн 94.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20, 14.4, Засгийн газрын 2017 оны 144, 2018 оны 80 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит ХҮИ хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд цэргийн жинхэнэ алба хаах хугацаа дуусч бэлтгэлээр халагдсан бэлтгэл байлдагч, түрүүчийг хүлээн авах, цэргийн жинхэнэ албанд иргэдийг татах, цэргийн дүйцүүлэх албанд авах ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 10-ний өдрөөс эхлэн мөн оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулж явуулсугай.

2. Цэрэг татлагын товчоог дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Товчооны дарга: Б.Мөнгөн-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Орлогч дарга: Хурандаа С.Батхуяг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга)

Гишүүдэд:

М.Алтаншагай (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Б.Батбилгүүн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

А.Алтанцоож Цагдаагийн хурандаа (Аймгийн Цагдаагийн газрын дарга)

Д.Түвшинбаяр (Аймгийн Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Г.Оюунжаргал (Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга)

Л.Юмжирдулам (Нийгмийн даатгалын хэлтсийн дарга)

Хошууч Б.Мөрөндалай-(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дайчилгааны офицер)

Захирамж-2023

671 010471



Нарийн бичгийн дарга: Дэд хурандаа Ү.Батбаяр -(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын Тоо бүртгэлийн офицер)

3. 2023 оны цэрэг татлагын эмнэлгийн урьдчилсан үзлэг явуулах хуваарийг нэгдүгээр, шаардагдах зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Цэрэг татлагын товчооны ажил үүргийн хуваарийг дор дурдсанаар тогтоож гишүүдэд үүрэг болгосугай.

а/ Цэрэг татлагын үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн баримт, тухайн ажлын онцлогийн талаар зааварчилгаа өгч, бусад зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (М.Алтаншагай)-д;

б/ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолоор батлагдсан “Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн албан хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам”-ыг удирдлага болгон эмнэлгийн урьдчилсан үзлэгийг зохион байгуулж Зэвсэгт хүчний Жанжин штабаас өгсөн тоон даалгаврыг биелүүлэхийг аймгийн Цэрэг татлагын товчооны орлогч дарга, (хурандаа С.Батхуяг), Нэгдсэн эмнэлгийн дарга ( Г.Оюунжаргал ) нарт;

в/ Эмнэлгийн үзлэг явуулах эмч нарын бүрэлдэхүүнийг мэргэжлийн дагуу томилон ажиллуулахыг Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Түвшинбаяр)-д;

г/ Бэлтгэлээр халагдаж ирсэн цэргийн үүрэгтнүүдийг бүртгэж ажлын байрны мэдээллээр хангаж, төрөл бүрийн сургалтад хамруулах арга хэмжээ авч ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Б.Батбилгүүн), Цэргийн штабын орон нутаг хамгаалалт, сургалтын офицер ( хошууч Т.Анхбаяр) нарт;

д/ Цэрэг халалт таталтын арга хэмжээний үед хэв журам сахиулах ажлыг ханган ажиллахыг Аймгийн Цагдаагийн газрын дарга,(Цагдаагийн хурандаа А.Алтанцоож)-д;


е/ Цэргийн жинхэнэ албаны татлагаар зарлан дуудах мэдэгдэл авсан иргэн тогтоосон өдөр, цагт цэрэг татлагын байр,товлосон газар ирээгүй бол хуульд заасан хариуцлага оногдуулж ажиллахыг Цэргийн штабын дарга (хурандаа С.Батхуяг)-д;

5. Цэргийн албанд татагдагчдын эрүүл мэндийн урьдчилсан болон давтан үзлэг, цэрэг халалт, татлагыг ямар нэгэн зөрчил дутагдалгүй зохион байгуулахыг Цэрэг татлагын товчооны дарга (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д даалгасугай.

6. Цэрэг халалт, таталт, эмнэлгийн үзлэг явуулахад шаардагдах зардалд нийт 26.280.840 (Хорин зургаан сая хоёр зуун наян мянга найман зуун дөчин) төгрөгийг 2023 оны цэрэг татлагын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

7. Энэ захирамжийг оролцогчид мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор эрх бүхий этгээдэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН



Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар  
сарын 21-ны өдрийн А/111 дугаар захирамжийн  
хавсралт

2023 ОНЫ ЦЭРЭГ ТАТЛАГЫН ЭМНЭЛГИЙН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ ХУВААРЬ

№	Сумдын нэр	Цэрэг бэлэн байх, бэлтгэл хангах		Үзлэг хийх хугацаа			Сум хоорондын зай км	Хонох тоо
		Сар, өдөр	Цаг	Сар өдөр	Цаг			
					Эхлэх	Дуусах		
1	Тосонцэнгэл	09/ІҮ	09 <sup>00</sup>	10/ІҮ	09 <sup>00</sup>	12 <sup>00</sup>	64	1
2	Түнэл	10/ІҮ	09 <sup>00</sup>	11/ІҮ	15 <sup>00</sup>	20 <sup>00</sup>	119	1
3	Мөрөн			12/ІҮ			45	1
4	Алаг-Эрдэнэ	12/ІҮ	09 <sup>00</sup>	13/ІҮ	09 <sup>00</sup>	15 <sup>00</sup>	62	1
5	Хатгал	13/ІҮ	09 <sup>00</sup>	14/ІҮ	16 <sup>00</sup>	20 <sup>00</sup>	42	1
6	Ханх	15/ІҮ	09 <sup>00</sup>	16/ІҮ	09 <sup>00</sup>	14 <sup>00</sup>	190	2
7	Чандмань-Өндөр	17/ІҮ	09 <sup>00</sup>	18/ІҮ	09 <sup>00</sup>	14 <sup>00</sup>	198	1
8	Цагаан-Үүр	18/ІҮ	09 <sup>00</sup>	19/ІҮ	17 <sup>00</sup>	20 <sup>00</sup>	60	1
9	Эрдэнэбулган	19/ІҮ	09 <sup>00</sup>	20/ІҮ	13 <sup>00</sup>	19 <sup>00</sup>	190	1
10	Тариалан	20/ІҮ	09 <sup>00</sup>	21/ІҮ	09 <sup>00</sup>	15 <sup>00</sup>	80	1
11	Их-Уул	21/ІҮ	09 <sup>00</sup>	22/ІҮ	16 <sup>00</sup>	20 <sup>00</sup>	42	1
12	Рашаант	22/ІҮ	09 <sup>00</sup>	23/ІҮ	09 <sup>00</sup>	16 <sup>00</sup>	90	1
13	Мөрөн	25/ІҮ	09 <sup>00</sup>	25 өдрөөс - 27	09 <sup>00</sup>	19 <sup>00</sup>	150	
14	Давтан үзлэг	ЗХЖШ-аас ирүүлсэн шийдвэрийн дагуу явагдана						
	Бүгд						1352	13

ЦЭРГИЙН ШТАБ



Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар  
сарын 21-ний өдрийн А / 111 дүгээр  
захирамжийн хоёрдугаар хавсралт

2023 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлага, цэргийн жинхэнэ албанд татагдагчдад  
эмнэлгийн үзлэг явуулах, үйлчлэх авто машины шатахуун бусад зардлын тооцоо

д/д	Явах чиглэл	ШТМ-ын зардал				
		Машины тоо	Явах км	Зарцуулах бензин	Нэг бүрийн үнэ	Нийт
1	Мөрөн-Тосонцэнгэл	2	64	28.8	3350	96480
2	Тосонцэнгэл-Түнэл	2	119	53.55	3350	179392.5
3	Түнэл-Мөрөн	2	45	20.25	3350	67837.5
4	Мөрөн-Алагэрдэнэ	2	62	27.9	3350	93465
5	Алагэрдэнэ- Хатгал	2	42	18.9	3350	63315
6	Хатгал-Ханх	2	190	85.5	3350	286425
7	Ханх-Чандмань өндөр	2	198	89.1	3350	298485
8	Чандманьөндөр-Цагаанүүр	2	60	27	3350	90450
9	Цагаанүүр-Эрдэнэбулган	2	190	85.5	3350	286425
10	Эрдэнэбулган-Тариалан	2	80	36	3350	120600
11	Тариалан-Их уул	2	42	18.9	3350	63315
12	Их уул- Рашаант	2	90	40.5	3350	135675
13	Рашаант-Мөрөн	2	150	67.5	3350	226125
14	Мөрөн	2	20	9	3350	30150
15	Дүн	2	1352	608.4	3350	2038140

Цэрэг татлагад 3 офицер, 12 эмч бүгд 15 хүн 11 суманд ажиллах томилолт  
15 хүн\*13 өдөр\*64000=12.480.000 төгрөг, машины хөлсөнд /жип нэг өдөр-150.000,  
пургон-90.000 / өдөр 240.000 төгрөг\* 13 = 3.120.000 төгрөг

Товчоо:

Сумдад ажиллах бензин	2.038.140
Машины хөлс	3.120.000
Албан томилолт	12.480.000
Хоолны зардал	4.622.800
Цэрэг хүргэх зардал	4.019.900
Нийт дүн:	26.280.840



Аймгийн Засаг даргын 2023 оны А/111 дүгээр захирамжаар нэгдүгээр ээлжийн цэрэг татлагаар  
цэрэг татлагын байранд ажиллагсад болон цэргийн албан татагдагчдыг хооллох зардлын тооцоо

д/д	Хооллох бүрэлдэхүүн	Хоолны төрөл					Хуний тоо	Хооллох тоо	Нийт дүн
		1-р хоол	2-р хоол	цай	талх	Бүгд			
1	Комисс	5000	7000	500	200	12700	16	3	609600
2	Эмч нар	5000	7000	500	200	12700	12	3	457200
3	Цэргийн албанд татагдагчид	5000	7000	500	200	12700	280	1	3556000
	Нийт								4622800

Цэрэг хүргэх зардал

д/д	Явах чиглэл	Унааны зардал			Албан томилолт				Нийт зардал
		Явах км	Зарцуулах бензин	Бүгд	Хуний тоо	Хоног	Зардал	Бүгд	
1	Мөрөн -Эрдэнэт	450	90	243000	2	2	142000	568000	811000
2	Эрдэнэт-Улаанбаатар	420	84	226800	2	8	142000	2272000	2498800
Хот дотор	Сонсголон-Хужирбулан - Сонсголон	40	8	21600					21600
	Сонсголон-Налайх -Сонсголон	90	18	48600					48600
	Сонсголон -Төв аймаг - Сонсголон	200	40	108000					108000
	Сонсголон -Алтанбулаг - Сонсголон	120	24	64800					64800
	Сонсголон -БХЯ – Улаанхуаран-Бөртэ оёдлын үйлдвэр	26	5	13500					13500
3	Улаанбаатар-Мөрөн	840	168	453600					453600
	Нийт	2186	437	1179900				2840000	4019900

ЦЭРГИЙН ШТАБ